

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН
ТУШААЛ

..... оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/205 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах, тайлангийн мэдээллийг ашиглах журам”-д доор дурдсан агуулгатай нэмэлт өөрчлөлтийг оруулсугай: Үүнд:

1.1.журмын 2.2.1 дахь хэсгийн “...бүртгэлтэй...” гэснийг ““татан бууж байна, хориг тавьсан, хэвийн” гэсэн төлөвтэй” гэж өөрчлөх;

1.2.журмын 2.8, 2.9, 3.4, 4.1.1, 4.1.2, 7.1.3 дахь хэсгийн “...баталгаажсан...” гэснийг “хүлээн авсан” гэж өөрчлөх;

1.3.журмын 2.9 дэх хэсгийн “...тохиолдолд...” гэснийг хасах;

1.4.журмын 2.13.6 дахь хэсгийн “...оруулсан...” гэсний дараа “...мэдээллийг зөвшөөрсөн” гэж нэмэх;

1.5.журмын 2.15 дахь хэсгийн “...баталгаажуулаагүй...” гэснийг “хүлээн авсан төлөвт шилжээгүй” гэж өөрчлөх;

1.6.журмын 2.18 дахь хэсгийн “...дараа дүгнэлтийг...” гэсний дараа “болон тайланг Аудитын тухай хуулийн 10.2-т заасан хугацаанд” гэж нэмэх;

1.7.журмын 3.5 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн төрийн өмчит, тэдгээрийн оролцоотой, засгийн газартай бүтээгдэхүүн хуваах, тогтвортой байдлын болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тусгайлан мэдээлсэн тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авахдаа журмын хавсралтаар батлагдсан тойрох хуудсанд харилцагч санхүүгийн байгууллагын асуудал хариуцсан бусад газраар хянуулж гарын үсэг зуруулсан байна.” гэснийг “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа төрийн болон орон нутгийн төрийн өмчит, тэдгээрийн оролцоотой, засгийн газартай бүтээгдэхүүн хуваах, тогтвортой байдлын болон хөрөнгө

оруулалтын гэрээ байгуулсан, тусгайлан мэдээлсэн тайлагнагч байгууллагууд санхүүгийн тайлангаа тус журмын хавсралтаар батлагдсан тойрох хуудсанд холбогдох асуудал хариуцсан газраар хянуулж гарын үсэг зуруулсан байна.” гэж өөрчлөх;

1.8.журмын 5.5 дахь хэсгийн “...(цаашид ”тайлан харах эрх” гэх)-ийг...” гэсний дараа “...болон эксел хэлбэрээр” гэж нэмэх;

1.9.журмын 5.5.2 дахь хэсгийн “тухайн” гэсний өмнө “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.3-т заасны дагуу” гэж нэмэх.

2.“Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах, тайлангийн мэдээллийг ашиглах журам”-д доор дурдсан агуулгыг нэмсүгэй. Үүнд:

2.1.журмын 3.9 дэх хэсэгт “журмын 3.5-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг хянах саналаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар (цаашид “НБББГ” гэх)-т тухайн жилийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор жагсаалтаар хүргүүлсэн байна.” гэж нэмэх;

2.2.журмын 2.19 дэх хэсэгт “Тухайн тайлант үеийн эхний үлдэгдэл нь өмнөх оны сүүлд хүлээн авсан төлөвтэй тайлангийн эцсийн үлдэгдэл байна.” гэж нэмэх;

2.3.журмын 5.9 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн мэдээлэл нийтэд ил тод байна.” гэж нэмэх;

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т үүрэг болгосугай.

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН